



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 5д

Алтай

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "г", 20 дугаар зүйлийн 20.1.14, Иргэний тухай хуулийн 318 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 51 дүгээр тогтоол, 2011 оны 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" тогтоолын 2 дугаар зүйлийн "а"-д заасан "Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх бол аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс зөвшөөрөл авах" гэснийг "Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх бол аймгийн Орон нутгийн өмчийн албанаас зөвшөөрөл авах" гэж өөрчилсүгэй.

2. Уг тогтоолд өөрчлөлт орсонтой холбогдуулан орон нутгийн өмчит байгууллага бүрт энэхүү тогтоолыг хүргүүлж, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Орон нутгийн өмчийн албаны дарга /Л.Ганхуяг/- д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ